
МЭДЭЭ · 2020 оны 5-р сарын 20

ШАТАХУУН ТҮГЭЭХ СТАНЦУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШАЛГАЖЭЭ



Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын прокурорын газраас тус сум дахь Гал унтраах, аврах 61 дүгээр анги, Мэргэжлийн хяналтын газартай хамтран шатахуун түгээх станцуудын үйл ажиллагаа хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд болон шууд бусаар хохирол учруулж байгаа эсэхийг шалгажээ.Тус сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг шатахуун түгээх станцууд нь галын аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлээгүй хэд хэдэн зөрчил шалгалтаар илэрснийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлсэн байна. Мөн нэг аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлд зааснаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахаар болжээ.



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/3138